БАТЛАВ
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА М.БАДАМСҮРЭН

ЖИМСНИЙ МОД ХҮНСНИЙ НОГОО ТАРИАЛАХЫГ ДЭМЖИЖ УСАН ХАНГАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ “НОГООН ГУДАМЖ” ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛГООР УСАЛГААНЫ СИСТЕМ СУУРИЛУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

1.Зорилго: Өрхийн тариалан эрхлэх сонирхолтой айл өрхийн дундын ашиглалтын усны эх үүсвэрийг бий болгож, бүлгийн зохион байгуулалтад оруулах замаар жимсний мод хүнсний ногоо тариалахыг дэмжиж усалгааны систем суурилуулан ус хангамжийг нэмэгдүүлэхэд “Ногоон гудамж” төслийн зорилго оршино.

Ач холбогдол төслийн нөлөөлөл

1.1. Өрхийн тариалан эрхлэхэд хүндрэлтэй байдаг усны асуудал шийдвэрлэгдэнэ.
1.2. Төмс, хүнсний ногоо тариалж зах зээлд нийлүүлэх замаар иргэн аж ахуйн нэгж орлогоо нэмэгдүүлнэ.
1.3. Өрхийн тариалангийн үйлдвэрлэл, хэрэглээ нэмэгдсэнээр өрхүүдийн хүнсний баталгаат байдал, амьдралын чанар сайжрахад нөлөөлнө.
1.4. Хураан авсан бүтээгдэхүүнээ дахин боловсруулж өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэснээр бичил бизнес эрхлэх боломж бүрдэнэ.
1.5. Төв суурин газрын ногоон байгууламжийн хэмжээ нэмэгдсэнээр агаарын бохирдлыг бууруулна.
1.6. Хүүхдэд бага наснаас нь экологийн боловсрол олгоно.
1.7. Ногоон гудамж төсөлд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд нэгдсэн зохион байгуулалтад орж хамтран ажиллах.
1.8. Төсөлд хамрагдсан иргэд дангаараа болон бүлгээрээ бизнес эрхлэх ур чадвар эзэмшиж, бусад айл өрхүүдэд хамтран ажиллахын давуу талыг сурталчилна.

2.Стандарт

2.1 Ус дамжуулахад зориулсан полиэтилен хоолой (PPR) техникийн тавигдах шаардлага: MNS ISO 4427: 2007 стандартыг мөрдөж ажиллана.

1	Үндэслэл	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар 02-ны өдрийн 13/08 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний 2.8.6 дахь арга хэмжээг хэрэгжүүлэх
2	Зорилт	Өрхийн болон хоршоо, бүлэг нөхөрлөлийн дундын ашиглалтын ногоон бүсэд жимсний мод хүнсний ногоо тариалалтыг дэмжиж усалгааны систем суурилуулан ус хангамжийг нэмэгдүүлэн, тариалан эрхлэгч нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.
3	Хөрөнгө оруулалт	Нийт төсөвт өртөг 250,000,000 төгрөг Ногоон гудамж төслийн талбай байгуулах ажилд 241,000,000 төгрөг Ногоон гудамж төслийн талбайн зааварчилгаа, сургалтын ажилд 9,000,000 төгрөг
4	Захиалагч	Дорнод аймгийн ЗДТГазар, Хүнс, хөдөө аж ахуйн газар
5	Цахилгаан хангамж	Цахилгаан дамжуулах агаарын шугам 6кВ-ын шугамаас цахилгаан хангамжийг татан 6/0,4кВ-ын дэд станц суурилуулан

		дэд станцаас харуулын байр, зөөврийн ариун цэврийн байр, худаг зэргийн цахилгаан хангамжийн 0,4кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам бетон тулгуурын хамт угсран ашиглалтад хүлээлгэж өгнө.
6	Эрх зүйн баримт бичиг	Монгол Улсын хуулиуд: - Газрын тухай болон Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль Технологийн аргачлалууд
7	Шугам хоолойн татах бүрдэл баримт бичиг	- Шугамын байгууламжийн байршлын бүдүүвч, байр зүйн зураг - Инженерийн шугам сүлжээний техникийн нөхцөлүүд - Эзэмшил газар олголтын захирамж зэрэг материалыг захиалагч бэлтгэж, гүйцэтгэгчид хүлээлгэн өгнө. - Шугамын ажлын зураг, ажлын даалгавар, бусад хавсралтууд зэрэг материалыг гүйцэтгэгч тал бэлтгэн, хүлээлгэн өгнө.
8	Хугацаа, үе шат	- -Нэг үе шаттай, 2023 оны 08, 09 дугаар сард
9	Гүн өрмийн цооног	- Гүн өрмийн худгийн ашиглалтын ундарга нь 2м3-ээс 6 м3 ус өгөх хүчин чадалтай - Гүн өрмийн цооногийн ундарга 1,5м3/сек - Цооногийн уснаас дээж авч шинжилгээ хийлгэсэн байна. - Гүний насос: ISO9001 стандартын шаардлага хангасан. Гар үүслийн гэрчилгээтэй байна. - Гүн өрмийн цооногт ф32 PPR хоолой суулгах - Гүн өрмийн цооногийн насос нь цахилгааны холболт хийгдсэн байна.
10	Усны шугам хоолойн байрлуулалт	-Усны нөөцийн савыг ф100мм-н ган хоолойгоор холбоно. -Усны нөөцийн савнаас гарах усалгааны төв шугамын эхний 60 метр ф70мм-ын PPR хоолой, дараагийн 70 метрт ф50мм-ын PPR хоолой байна. -Усалгааны системийн төв шугамаас схем зургийн дагуу 1.5 метр урттай ф32мм-ын PPR хоолойг холбож хаалт суурилуулна.
11	Ус хуримтлуулах усан сан	-Усны нөөцийн савын хоорондын зай 40 метрээс ихгүй байна. -Усны нөөцийн төмөр сав нь 25 тоннын 4 ширхэг нөөцийн сав байна. -Усны нөөцийн савны амсарт гарах шаттай байна. -Усны нөөцийн савыг схем зургийн дагуу байрлуулж шугам хоолойн оролт гаралтын холболтыг хийнэ. -Усны нөөцийн сав нь шинэ байна.
12	Хашаа	Төмөр торон хашаа - Хашаа нь ижил бүрдэл хэсэгтэй байна. Өндөр 1,5м, урт нь 700м / хашааны хэмжээ 200*150м нийт 3га / - Хашааны шон нь 2м урт ф50мм-н голчтой труба шонтой байх ба трубаг захиалагч тал хангана. - Ф32мм-н труба шонд хашааны төмөр тор тогтоох зориулалт бүхий нүхэлж хашааны торыг ган утсаар тогтооно. Хашааны шонг газарт 50см суулгана. Торыг шонд нарын төмөр утас /Цэгэн утас/-р бэхэлж тогтооно. Шон хоорондын зай 3м байна. Хашааны дөрвөн буланд тулаас бэхлэгээ хийнэ. Хашааны бэхэлгээ - Торны дээгүүр шон хооронд нэг эгнээ 3мм цайрдсан төмөр утсаар бэхэлнэ. Машины орж гарах хаалга - Машины хаалганы урт 4 метр урт өндөр нь 1,8м хаалганы шонг ф80-н ган трубагаар хийнэ. Хаалганы гадна рамыг 40*20 мм-ийн квадрат төмрөөр хийнэ. - Шонгийн газарт суух гүн 70см-ээс багагүй байж М150 маркийн бетоноор цутгаж шонг бэхэлж өгнө. Хаалга нь 2 байна. - Машины хаалга 2 шон дээрээсээ чангалагч татуургатай байна.
13	Хяналтын камер	- Хяналтын камер нь гадна зориулалтын нэг чигийн камер 5 ширхэг байна. • Дүрсний нягтрал 5MP, 2592x1520 • Харан өнцөг 16-44мм • Харах зай 50м-56м • Ауди дэмжигч

		• Ауди дэмжигч • Нэмэлт лед гэрэлтүүлгийн лампа 12ш байна. • Хэвийн ажиллах температур -45^{O}C – 60^{O}C • ONVIF H6265+ • 12вольт • Night color тохиргоо, Night B/W тохиргоонуудтай байна. - Хяналтын камерыг хашааны 2 буланд газраас дээш 4м өндөр шонд тойм зургийн байршлын дагуу байрлуулан цахилгаан болон дүрс дамжуулах сүлжээний холболтыг хийнэ. - Хяналтын камерын бичигч нь 8 суваг бичих зориулалттай байна. Бичигч төхөөрөмжийн хатуу диск нь 500GB багтаамжтай байна. - Хяналтын дэлгэц нь 21 инч байна.
14	Зөөврийн ариун цэврийн байгууламж	- 3*6м Хэмжээтэй зөөврийн ариун цэврийн байр байна. Төмөр карказ бүхий рамтай дээврийн гадаргуу налуу, сууцны дээврийн хүрээ нь тэгш өнцөгт шулуун байна. - Бие засах тасалгаа 4, угаалтуур 2, усны нөөцийн сав болон сангийн холболтын ажлын зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.
15	Харуулын байр	- 3*3м Хэмжээтэй зөөврийн сууц байна.
16	Зөвлөх үйлчилгээ	Жимсний мод хүнсний ногоо тариалахыг дэмжиж усан хангамжийг нэмэгдүүлэх “Жишиг ногоон гудамж” төсөлд хамрагдсан айл өрхүүдэд услалтын системийг ашиглах хүнсний ногоо, жимсний мод тарих арга технологийг зааж сургах, хоршиж бизнес эрхэлж өрхийн орлогыг нэмэгдүүлэх боломжийн талаар зөвлөх үйлчилгээг үзүүлнэ.

Монгол Улсын Хөдөө аж ахуйн сайд, Байгаль орчны сайд, Сангийн сайдын 2005 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн 101, 189, 194 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан “Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах нийтлэг журам”-ыг мөрдөнө.

ХЯНАСАН:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН,
ХЭЛТСИЙН ДАРГА М.НЯМСҮРЭН

БОЛОВСРУУЛСАН:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН ИНЖЕНЕРИЙН ЗУГАМ СҮЛЖЭЭ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Б.УРАНСҮХ

АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Д.МӨНХБАЯР